

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН МЭДЭЭ

/2015 он/

Төрийн байгууллагын соёл болон төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх нь тус зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамааралтай үүрэг, зорилтын нэг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2015 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллалаа.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороонуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн үзвэл 2015 онд нийт **212** ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс:

- Төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой **28**,
- Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчтай холбоотой **184** ёс зүйн зөрчил бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад нэг дахин буурсан үзүүлэлттэй байна.

Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр нэгтгэн гаргав. Үүнд:

	Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авсан үндэслэл					Ёс зүйн зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох		ТАХ-ийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал					
	Журмын 1.2		Журмын 2.2.5			Анх	Давтан	Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн эсэх		Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр			
	Гомдлоор	Мэдээллээр	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр	Ёс зүйн хороо өөрийн санаачлагаар	Байгууллагын удирдлагын шийдвэрээр			Зөвшөөрсөн	Зөвшөөрөөгүй	ТАХ-ын 26.1.1	ТАХ-ын 26.1.2	ТАХ-ын 26.1.3	Сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн
2015 он													
Удирдах албан тушаалтан	9	5	1	1	12	26	2	25	3	13	11	1	3
	<b>28 ёс зүйн зөрчил</b>												
Гүйцэтгэх албан тушаалтан	24	11	16	11	122	136	48	160	24	87	46	14	37
	<b>184 ёс зүйн зөрчил</b>												
Нийт ёс зүйн зөрчил	33	16	17	12	134	162	50	185	27	100	57	15	40
	<b>212 ёс зүйн зөрчил</b>												

Дээрх хүснэгтээс харахад төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэн ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол **12** байхад байгууллагын удирдлагын санаачлага, шийдвэрээр ёс зүйн зөрчлийг авч хэлэлцсэн тохиолдол **134** байна.

Харин ёс зүйн хороод хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтат мэдээлэл болон өөрийн санаачлагаар төрийн албан хаагчийн ёс зүйн үйлдлийг авч хэлэлцсэн тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь ёс зүйн хороод өөрийн санаачлагатай, идэвхитэй ажиллах байдал сулавтар байгааг харуулж байна.

Ёс зүйн зөрчлийг анх удаа гаргасан **162** албан хаагч байгаа бол давтан гаргасан **50** албан хаагч байгаагаас Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн **185**, хүлээн зөвшөөрөөгүй **27** албан хаагч байна.

Ёс зүйн хороод төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой иргэдийн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тухайн асуудлыг авч хэлэлцээд тэдгээр зөрчилд сахилгын шийтгэл оногдуулах эсэх шийдвэрийг гаргадаг. 2015 онд дээрх **212** ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг авч хэлэлцээд:

- **19 хувьд нь буюу 40 тохиолдолд нь сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй**

гэсэн шийдвэрийг гаргасан бол нийт зөрчлийн:

- **81 хувь буюу 172 зөрчилд нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргажээ.**

Ёс зүйн хороодын дээрх шийдвэрээр төрийн албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийг төрлөөр авч үзвэл:

- 100 албан хаагчид -сануулах /ТАТХ-ийн 26.1.1/,
- 57 албан хаагчид -албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах /ТАТХ-ийн 26.1.2/,
- 15 албан хаагчид -төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах /ТАТХ-ийн 26.1.3/ гэсэн сахилгын шийтгэлийг тус тус ногдуулжээ.

Эндээс харахад материаллаг /цалин бууруулах/ болон ёс зүйн /сануулах/ шийтгэл зонхилж байгаа нь харагдана. Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл нийт сахилгын шийтгэлийн 8,7 хувийг эзэлж байгаа бөгөөд ийм шийтгэл авсан албан хаагч 14 байхад удирдах албан тушаалтан 1 байлаа.

Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай сүүлийн 5 жилийн байдлыг харьцуулан үзэхэд өнгөрөгч 2015 онд бүртгэгдэж ёс зүйн хороодоор хэлэлцэгдсэн зөрчлийн тоо өмнөх жилийн буюу 2014 оны дүнгээс **135**-аар буюу **39** хувиар буурсан байна.

**Ёс зүйн зөрчлийг сүүлийн 4 жилийн байдлаар харьцуулан үзвэл:**

